


## 2. Асуулга үүсгэх

### 2. Асуулга үүсгэх

Миний асуулга цэсийг сонгоход асуулгын жагсаалт харагдана. Энд өмнө нь үүсгэсэн асуулгууд байрлана. Анх удаа нэвтэрч байгаа хэрэглэгчийн хувьд зөвхөн **Нэмэх** товч харагдана. Шинээр асуулга үүсгэхийн тулд **Нэмэх** товчийг дараад хадгалахад Шинэ төлөвтэй үүсэх юм.



**Нэмэх** товчийг дарахад дараах бүтэц бүхий цонх гарч ирнэ.

1. Харах
2. Логик
3. Загвар
4. Тохиргоо
5. Хадгалах
6. Гарчиг
7. Асуулт нэмэх

[← Буцах](#)[Харах](#)[Логик](#)[Загвар](#)[Тохиргоо](#)[Хадгалах](#)

Хэсэг 1

+

[+ НЭМЭХ](#)

## 2.1 Харах

Асуулга нь хэрэглэгчийн төхөөрөмж дээр хэрхэн харагдах вэ гэдгийг урьдчилан шалгахдаа **Харах** товчийг дарж харна. Компьютер болон гар утас дээр харж болох сонголттой.

## Ерөнхий боловсролын сургуульд интернетийн дотоод сүлжээ байгуулах төслийн судалгаа

Сургуулийн интернетийн дотоод сүлжээний нөхцөл байдлын судалгааг үнэн зөв бөглөх шаардлагатай.

\* 1.

Хариулт 1

## Сургуулийн интернет хариуцсан албан хаагчийн мэдээлэл

Хариуцан ажиллах ажилтан, албан тушаалтны мэдээллийг үнэн зөв бөглөнө үү. Тухайн ажилтан esis.edu.mn системд бүртгэлтэй байх шаардлагатай.

\* 1. Ажилтны овог, нэр

Хариулт 1

Дээрх зураг нь компьютерийг сонгоход асуулгын харагдах байдал байна.

Гар утсыг сонгоход дараах байдалтай харагдана.

# Ерөнхий боловсролын сургуульд интернетийн дотоод сүлжээ байгуулах төслийн судалгаа

Сургуулийн интернетийн дотоод сүлжээний нөхцөл байдлын судалгааг үнэн зөв бөглөх шаардлагатай.

\* 1.

Хариулт 1

Сургуулийн

## 2.2 Загвар

Асуулгын арын өнгийг асуулгын хэв маягт тохируулж өөрчлөх боломжтой.

Мөн зураг upload хийж асуулгыг загварыг тохируулна. Үүний тулд **Зураг** гэсэн товчийг дарж өөрийн төхөөрөмж дээрх зургаас сонгож оруулна.

## 2.3 Тохиргоо

Энэ хэсэгт асуулгатай холбоотой тохиргоонуудыг хийдэг байна.

**Эхлэх огноо, дуусах огноо:** Эдгээр огноог тохируулснаар эхлэх, дуусах хугацааны хооронд санал асуулгыг бөглөх боломжтой.

**Баярлалаа текст:** Асуулгыг бөглөж дууссаны дараа хэрэглэгчид харуулах текстийг оруулна.

**Төрөл:** Энэ нь Нээлттэй, Хаалттай, Хамгаалалттай гэсэн сонголттой.

- Нээлттэй асуулга нь бүх хүнд нээлттэй, чөлөөтэй бөглөх боломжтой.
- Хаалттай асуулга нь нууц код хийж бөглөх боломжтой.
- Хамгаалалттай асуулга нь Боловсролын салбарын мэдээллийн системд ([www.esis.edu.mn](http://www.esis.edu.mn) болон БСМС-ийн бусад дэд системүүд) бүртгэлтэй хэрэглэгчдийг тодорхойлж өгснөөр бөглөх боломжтой. БСМС-д нэвтрэх эрхтэй бол бөглөх боломжтой асуулга гэсэн үг юм.

**Шатлалтай эсэх:** Энэ сонголт нь зөвхөн хамгаалалттай төрлийг сонгох үед гарч ирнэ. Шатлалгүй ба шатлалтай гэсэн сонголттой байна. Шатлал гэдэг нь боловсролын салбарын урьдчилан тодорхойлсон мэдээлэл дамжуулах, хянах мэдээллийн урсгалыг хэлнэ. Өөрөө хэлбэл, Ерөнхий боловсролын сургуулийн хувьд шатлал нь **Яам <-> Боловсрол соёлын газрын <-> ЕБС** гэсэн шатлалтай байна. Жишээ нь, яамны мэргэжилтэн шатлалтай асуулга үүсгэж бүх ЕБС-ийн багш нар луу илгээсэн тохиолдолд Боловсролын газрын холбогдох мэргэжилтэн явцыг харж хянах боломжтой болно гэсэн үг юм. Харин дээрх тохиолдолд шатлалгүй асуулга үүсгэсэн бол зөвхөн Яам <-> ЕБС гэсэн дамжлага үүсэх юм.

- Шатлалгүйг сонгосон үед
- Хаалттай асуулга нь нууц код хийж бөглөх боломжтой.

[← Буцах](#)[Харах](#)[Логик](#)[Загвар](#)[Тохиргоо](#)[Хадгалах](#)

## Тохиргоо

 Эхлэх огноо

2021-10-11 10:22

 Дуусах огноо

2021-11-30 23:59

 Баярлалаа текстСудалгаанд оролцсон  
Танд баярлалаа!

Төрөл:

Нээлт...

<https://iform.e>

Ерөнхий боловсролын сургуульд интернетийн дотоод сүлжээ байгуулах төслийн судалгаа

Сургуулийн интернетийн дотоод сүлжээний нөхцөл байдлын судалгааг үнэн зөв бөглөх шаардлагатай.

## Хэсэг 1

\* 1.

Хариулт 1

## Хэсэг 2

Сургуулийн интернет хариуцсан албан хаагчийн мэдээлэл

Хариуцан ажиллах ажилтан, албан тушаалтны мэдээллийг үнэн зөв бөглөнө үү. Тухайн ажилтан esis.edu.mn системд бүртгэлтэй байх шаардлагатай.